

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ **КОНВЕНЦ**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL

ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

Тамхины хяналтын суурь конвенц

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/i/item/9241591013>

ОРШИЛ ХЭСЭГ

Энэхүү Конвенцийн Оролцогч Талууд,

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах эрхийг нэн тэргүүнд болгохыг *тодорхойлон*,

Тамхины тахлын тархалт нь нийгмийн эрүүл мэндэд ноцтой үр дагаварт хүргэх, дэлхий дахины хэмжээний асуудал болсон болон үүний төлөө хамгийн өргөн хүрээний олон улсын хамтын ажиллагаа, бүх орнуудын оролцоотой олон улсын үр дүнтэй, зохих ёсны, олон талт хариу үйл ажиллагаа шаардагдаж байгааг *хүлээн зөвшөөрч*,

Тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдсэнээс үүсэх дэлхий дахины эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг болон байгаль орчинд сөрөг үр дагавар үүсч байгаа талаар олон улсын хамтын нийгмийн санаа зовж байгааг *илэрхийлж*,

Дэлхий дахинд тамхи болон тамхин бусад бүтээгдэхүүний хэрэглээ, үйлдвэрлэл ихсэж байгаа, ялангуяа хөгжиж буй орнуудад, гэр бүл, ядуучууд ба үндэсний эрүүл мэндийн тогтолцоонд ачаалалтай байгаа нь онцгой анхаарал татах болсныг *тэмдэглэж*,

Тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдэх нь үхэл, өвчлөл, хөдөлмөрийн чадвар алдагдахад хүргэдэг нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхой батлагдсан, тамхи татах болон тамхийг бусад аргаар хэрэглэсний дараа тодорхой хугацаа өнгөрч тамхитай холбоотой өвчин үүсч эхэлдэг гэдгийг *хүлээн зөвшөөрч*,

Янжуур болон тамхи агуулсан бусад бүтээгдэхүүн нь тамхинд дасал үүсгэж түүнийг байлгах зорилгоор өндөр түвшинд зохион бүтээсэн, тамхинд агуулагдаж буй болон утаагаар биед орж буй олон бодис эм зүйн хувьд идэвхтэй, хортой, мутаци болон хавдар үүсгэх чадвартай байдаг болон тамхины дасал өвчнийг олон улсын томоохон ангиллуудад тусгай бие даасан өвчин гэж үзэх болсныг *хүлээн зөвшөөрч*,

Жирэмслэлтийн үед тамхины утаанд нэрвэгдэх нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байдгийг нотолсон шинжлэх ухааны баталгааг *хүлээн зөвшөөрч*,

Хүүхэд, өсвөр үеийнхний дунд, тамхи татах болон тамхийг бусад замаар хэрэглэх нь дэлхийн хэмжээгээр өсч, энэ нь ялангуяа улам бүр залуужиж байгаад санаа зовниж байгааг *илэрхийлж*,

Эмэгтэйчүүд, залуу охидуудын дунд, тамхи татах болон тамхийг бусад замаар хэрэглэх нь дэлхийн хэмжээгээр өсч байгаа талаар санаа зовниж байгааг *илэрхийлэн*, бүх үе шатны бодлого боловсруулах болон хэрэгжүүлэхэд тэдний оролцоо хэрэгтэй байгааг үндэслэн хүйсийн онцлогийг харгалзсан тамхины хяналтын стратеги хэрэгтэй байгааг *санаж*,

Нутгийн уугуул хүмүүсийн тамхи татах болон тамхийг бусад замаар хэрэглэх явдал өндөр түвшинд хүрсэн явдалд маш ихээр санаа зовниж, Тамхин бүтээгдэхүүний хэрэглээг дэмжсэн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх бүх хэлбэрийн үйл ажиллагааны үр нөлөөний талаар *санаа их зовниж*,

Янжуур болон бусад тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны бүх хэлбэр, түүний дотор хууль бус худалдаа, хууль бус үйлдвэрлэл ба хуурамчаар үйлдэх зэргийг устгахад бүх Талуудын хамтын ажиллагаа шаардлагатай байгааг *танин мэдэж*,

Бүх түвшний тамхины хяналт, ялангуяа хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй улс орнууд дахь тамхины хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай, тохирсон, хүрэлцэх хэмжээний санхүү, техникийн эх үүсвэр өнөө үед болон цаашдаа шаардлагатай байгааг *хүлээн зөвшөөрч*,

Тамхины хэрэгцээг үр дүнтэй бууруулах стратегийн удаан хугацааны нийгэм, эдийн засгийн үр нөлөөнд хандсан зохих механизмуудыг боловсруулах шаардлагатай байгааг *хүлээн зөвшөөрч*,

Тамхины хяналтын хөтөлбөрүүд зарим хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй улс орнуудад дунд ба удаан хугацаанд эдийн засгийн хүндрэл учруулж болзошгүй гэдгийг анхаарч тэдгээрт үндэсний хЭМЖЭЭНД боловсруулсан тогтвортой хөгжлийн стратегиудын хүрээнд техникийн болон санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг *хүлээн зөвшөөрч*,

Олон улс орнууд тамхины хяналтын талаар чухал ажил гүйцэтгэж байгааг мэдэж Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тэргүүлэх үүрэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцооны бусад байгууллага болон бусад олон улсын ба бүс нутгийн засгийн газрын хоорондын байгууллагуудаас тамхины хяналтын арга хэмжээнүүдийг боловсруулах талаар гаргасан хүчин чармайлтыг *сайшааж*,

Төрийн бус байгууллага болон тамхины үйлдвэрлэлтэй холбоогүй иргэний нийгмийн бусад гишүүд болох мэргэжлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмэгтэйчүүд, залуучууд, байгаль орчны хамгаалал, хэрэглэгчдийн бүлгүүд, шинжлэх ухааны болон эрүүл мэндийн байгууллагуудын тамхины хяналтын хүчин чармайлтад оруулсан хувь нэмэр болон тэдгээрээс тамхины хяналтын үндэсний ба олон улсын хүчин чармайлтад оролцох нь нэн чухал байгааг *онцлон тэмдэглэж*,

Тамхи үйлдвэрлэгчдээс тамхины хяналтын арга хэмжээнүүдийг сулруулах буюу хорлон сүйтгэх гэсэн ямар нэгэн хүчин чармайлтад сонор сэрэмжтэй байх, тамхи үйлдвэрлэгчдийн талаас тамхины хяналтын арга хэмжээнд сөргөөр нөлөөлж болох аливаа үйлдлийн талаар мэдээлэлтэй байх шаардлагатайг *хүлээн зөвшөөрч*,

1966 оны 12-р сарын 16-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Эдийн засаг, Нийгэм ба Соёлын Эрхийн Олон улсын актын 12 дугаар зүйлд зааснаар хүн бүр хамгийн өндөр стандартын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авах эрхтэй гэдгийг *эргэн санаж*,

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Дүрмийн оршил хэсэгт зааснаар арьсны өнгө, шашин, улс төрийн итгэл, эдийн засаг буюу нийгмийн талаас ялгаварлахгүйгээр хамгийн өндөр стандартын эрүүл мэндийн тусламж авах нь хүн бүрийн үндсэн эрхүүдийн нэг гэдгийг *мөн эргэн санаж*,

Орчин үеийн болон холбогдох шинжлэх ухаан, техник болон эдийн засгийн үндэслэлийн дагуу тамхины хяналтын арга хэмжээнүүдийг *дэмжихээ илэрхийлэн*,

1979 оны 12-р сарын 18-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенцид уг Конвенцийн Оролцогч Улсууд эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах талаар зохих арга хэмжээ авах тухай заасныг *эргэн санаж*,

1989 оны 11-р сарын 20-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүүхдийн эрхийн тухай Конвенцид уг Конвенцийн Оролцогч Улсууд хамгийн өндөр стандартын эрүүл мэндийн тусламж эдлэх хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай заасныг *цаашид эргэн санаж*,

Дараах зүйлсийг *хэлэлцэн тохиров*.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА

1 дүгээр зүйл

Нэр томъёог хэрэглэх

Энэхүү Конвенцийн зорилгоор:

- (а) “хууль бус худалдаа” гэдэг нь хуулиар хориглосон болон үйлдвэрлэх, тээвэрлэх, хүлээн авах, эзэмших, түгээх, худалдах буюу худалдаж авахтай холбоотой аливаа үйл ажиллагаа буюу арга барилыг хэлэх бөгөөд түүний дотор тийм үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн аливаа үйл ажиллагаа буюу арга барил;
- (б) “бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага” гэдэг нь хэд хэдэн тусгаар тогтносон улсаас бүрэлдсэн Гишүүн Улсууд хэргийн хүрээнд эрхээ шилжүүлсэн түүний дотор Гишүүн Улсуудын нэрийн өмнөөс хэд хэдэн төрлийн хэргийн хувьд гаргасан шийдвэрийг биелүүлэх байгууллагыг хэлнэ;¹
- (в) “тамхийг сурталчлах болон дэмжлэг үзүүлэх” гэдэг нь тамхин бүтээгдэхүүний буюу тамхины хэрэглээг шууд эсхүл шууд бусаар дэмжих зорилготой, үр дүнтэй буюу байж болох худалдааны мэдээлэл, зөвлөгөө өгөх буюу үйл ажиллагааны аливаа хэлбэрийг хэлнэ;
- (г) “тамхины хяналт” гэдэг нь тамхины хэрэглээг багасгах, тамхины утаанд нэрвэгдэх явдлыг бууруулах замаар хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад чиглэсэн тамхины нийлүүлэлт, эрэлт хэрэгцээ болон хор хөнөөлийг бууруулахад чиглэсэн стратегийн хүрээг хэлнэ;
- (д) “тамхины үйлдвэрлэгч” гэдэг нь тамхин бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид, бөөний худалдааны нийлүүлэгчид, импортлогчдыг хэлнэ;
- (е) “тамхин бүтээгдэхүүн” гэдэг нь татах, сорох, зажлах буюу үнэрлэх зорилгоор хэрэглэж болох тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг хэлнэ;
- (ё) “тамхины ивээн тэтгэлэг” гэдэг нь тамхин бүтээгдэхүүний хэрэглээг шууд буюу шууд бусаар дэмжих зорилго, үр дүнтэй болгох үүднээс аливаа үйлдэл, үйл ажиллагаа буюу хувь хүнд хандив дэмжлэг үзүүлэх аливаа хэлбэрийг хэлнэ.

2 дугаар зүйл

Энэхүү Конвенц болон бусад хэлэлцээр, хуулийн баримт бичгүүдийн хоорондын холбоо

1. Хүний эрүүл мэндийг илүү сайн хамгаалах зорилгоор Талууд энэхүү Конвенц болон түүний тогтоолуудад шаардаж буй хэмжээнээс илүү арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжиж байгаа бөгөөд энэхүү баримтуудад Талуудыг тэдгээрийн хууль тогтоомж, олон улсын эрх зүйн дагуу илүү хатуу арга хэмжээ авахыг хориглох зүйл байхгүй болно.

¹ Үндэсний хүсэл зориг бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагад үүний нэгэн адил хамаарна.

2. Энэхүү Конвенц болон түүний протоколуудын заалтууд нь Талуудын энэхүү Конвенц болон түүний протоколуудтай холбоотой буюу нэмэлт асуудлаар хоёр талын буюу олон талт хэлэлцээр, түүний дотор бүс нутгийн буюу дэд бүсийн хэлэлцээр байгуулах эрхэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй бөгөөд тийм хэлэлцээрүүд нь энэхүү Конвенц болон түүний протоколуудын дагуу гүйцэтгэх үүрэгтэй нийцэх болно. Холбогдох Талууд Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан Талуудын Бага хуралд тийм хэлэлцээрүүдийн тухай мэдэгдэнэ.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ БА ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

3 дугаар зүйл

Зорилго

Энэхүү Конвенц болон түүний протоколуудын зорилго нь тамхины хэрэглээний түвшин, тамхины утаанд нэрвэгдэх явдлыг тасралтгүй бөгөөд үлэмж хэмжээгээр бууруулах зорилгоор Оролцогч Талууд үндэсний, бус нутгийн болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх Тамхины хяналтын арга хэмжээний хүрээг бий болгох замаар тамхины хэрэглээ, тамхины утаанд нэрвэгдэх явдлаас үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн аймшигт үр дагавраас одоо ба хойч үеийнхнийг хамгаалахад оршино.

4 дүгээр зүйл

Баримтлах зарчим

Уг Конвенц болон түүний протоколуудын зорилгыг биелүүлэх, тэдгээрийн заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд Оролцогч Талууд бусад зүйлийн зэрэгцээ дор дурдсан зарчмуудыг баримтлан ажиллана:

1. Хүн бүрт тамхины хэрэглээ, тамхины утаанд нэрвэгдэх явдлаас үүдэлтэй эрүүл мэндийн үр дагавар, дасал үүсэх мөн чанар, амь насанд учруулах аюулын талаар мэдээлэх ёстой бөгөөд бүх хүмүүсийг тамхины утаанд нэрвэгдэхээс сэргийлэх зорилгоор засгийн газраас зохих түвшинд хууль зүй, гүйцэтгэх, захиргаа болон бусад төрлийн үр дүнтэй арга хэмжээнүүдийг авах талаар эргэцүүлэн бодох хэрэгтэй.
2. Дор дурдсан зүйлсийг анхааралдаа аван:
 - (а) бүх хүмүүсийг тамхины утаанд нэрвэгдэх явдлаас хамгаалах шаардлага;
 - (б) тамхинд орохын эсрэг болон тамхинаас гарахыг сурталчилж дэмжих болон бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах шаардлага;
 - (в) нутгийн уугуул иргэд, нийгэм хамт олон тэдгээрийн хэрэгцээ, баримтлах үзэлд нийгэм соёлын талаас нийцсэн тамхины хяналтын хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ өгөхөд татан оролцуулах талаар арга хэмжээ авах шаардлага; болон
 - (г) тамхины хяналтын стратегиудыг боловсруулахдаа хүйсийн онцлог эрсдэлд хандсан арга хэмжээ авах шаардлага.

3. Орон нутгийн соёл, мөн нийгэм, эдийн засаг, улс төр ба хууль зүйн хүчин зүйлсийг харгалзан тамхины хяналтын үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ялангуяа технологи, мэдлэгийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх, экспертиз явуулах зэрэг олон улсын хамтын ажиллагаа нь уг Конвенцийн чухал хэсэг мөн.
4. Нийгмийн эрүүл мэндийн зарчимтай уялдуулан тамхины хэрэглээ, тамхины утаанд нэрвэгдэх явдлаас үүдэлтэй өвчний гарал үүсэл, хөдөлмөрийн чадвар эрт алдалт, нас баралтаас урьдчилан сэргийлэх зорилгоор тамхины бүх төрлийн бүтээгдэхүүний хэрэглээг үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд бууруулах талаар олон салбарыг хамарсан иж бүрэн арга хэмжээ, хариу үйлдлүүд шаардлагатай байна.
5. Оролцогч Талуудын өөрсдийн хууль зүйн хүрээнд тогтоосон тамхинаас гаралтай хохирлыг хариуцах асуудлууд нь тамхины иж бүрэн хяналтын чухал хэсэг мөн.
6. Зарим хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй улс орнуудад тамхины хяналтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний улмаас хохирч болзошгүй тамхины ургамал тариалагчид болон ажилчдад эдийн засгийн шилжилт хийхэд техник, санхүүгийн дэмжлэг чухал ач холбогдолтой байгааг хүлээн зөвшөөрч энэ асуудлыг үндэсний хэмжээнд боловсруулсан тогтвортой хөгжлийн стратегиудын хүрээнд авч үзэх ёстой.
7. Конвенц болон түүний протоколуудын зорилгод хүрэхэд иргэний нийгмийн оролцоо амин чухал хэрэгтэй байна.

5 дугаар зүйл

Ерөнхий үүрэг

1. Оролцогч Тал бүр энэхүү Конвенц болон өөрийн оролцдог протоколуудтай нийцүүлэн олон салбарыг хамарсан тамхины иж бүрэн хяналтын үндэсний стратеги, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, тогтмол хянан шинэчилж байх үүрэгтэй.
2. Үүнийг биелүүлэхийн тулд Оролцогч Тал бүр өөрийн хүчин чадлын хүрээнд дор дурдсан зүйлсийг хэрэгжүүлнэ:
 - (а) тамхины хяналтын үндэсний зохицуулах механизм буюу төв цэгүүдийг байгуулах буюу бэхжүүлэх болон санхүүжүүлэх;
 - (б) тамхины хэрэглээ, никотины дасал, тамхинд нэрвэгдэх явдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны ба/буюу бусад арга хэмжээнүүдийг хүлээн авч хэрэгжүүлэх болон бусад Оролцогч Талуудтай шаардлагатай үед энэ талаар хамтарч ажиллан зохих бодлогуудыг боловсруулна.
3. Оролцогч Талууд тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг боловсруулах болон хэрэгжүүлэх явцад эдгээр бодлогуудыг тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт эрх ашгаас үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаална.
4. Оролцогч Талууд Конвенц болон оролцогч Талууд болох протоколуудыг хэрэгжүүлэхэд санал болгож буй арга хэмжээ, журам болон удирдамжуудыг тодорхойлоход хамтран ажиллана.

5. Оролцогч Талууд Конвенц болон оролцогч Талууд болох протоколуудын зорилтуудыг биелүүлэхэд олон улсын болон бүс нутгийн засгийн газрын хоорондын байгууллагууд болон бусад байгууллагуудтай хамтран ажиллана.
6. Оролцогч Талууд Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрүүдийг өөрийн мэдэлд буй хэрэгсэл, эх үүсвэрийн хүрээнд хоёр ба олон талын санхүүжүүлэх механизмаар дамжуулан хамтран ажиллана.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ТАМХИНЫ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭГ БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

6 дугаар зүйл

Тамхины эрэлт хэрэгцээг бууруулах татвар ба үнийн арга хэмжээ

1. Оролцогч Талууд үнэ болон татварын арга хэмжээнүүд нь хүн амын бүх бүлэг, ялангуяа залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад үр дүнтэй, чухал арга хэмжээ мөн хүлээн зөвшөөрч байна.
2. Оролцогч Талуудын татвар тодорхойлох, тогтоох бодлогын биеэ даасан эрхийг хөндөхгүйгээр Оролцогч Тал бүр өөрийн үндэсний эрүүл мэндийн зорилтуудыг харгалзан үзэж тамхины хяналтын талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх:
 - (а) тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн зорилтуудад хувь нэмэр оруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүний татварын бодлого шаардлагатай үед үнийн бодлого авч хэрэгжүүлэх;
 - (б) олон улсын зорчигчдод татвар, гаалийн хураамжаас чөлөөлсөн тамхин бүтээгдэхүүнийг худалдахыг шаардлагатай гэж үзвэл хориглох буюу хязгаарлах ба/буюу тэдэнд эдгээр тамхин бүтээгдэхүүнийг импортлохыг хориглох.
3. Оролцогч Талууд тамхин бүтээгдэхүүний татварын хэмжээ болон тамхины хэрэглээний хандлагын талаарх мэдээллийг тогтмол ирүүлэх тайлангуудад тусгаж, 21 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч Талуудын Бага хуралд ирүүлнэ.

7 дугаар зүйл

Тамхины эрэлт хэрэгцээг бууруулах үнийн бус арга хэмжээ

Олон талыг хамарсан үнийн бус арга хэмжээнүүд нь тамхины хэрэглээг бууруулах үр дүнтэй, чухал хэрэгсэл мөн гэдгийг Оролцогч Талууд хүлээн зөвшөөрч байна. Оролцогч Тал бүр 8 ба 13 дугаар зүйлд заасан үүргүүдийг биелүүлэхэд шаардлагатай үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны болон бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд боломжтой байдлаар харилцан шууд буюу эрх бүхий олон улсын байгууллагуудаар дамжуулан эдгээр үүргүүдийг биелүүлэхэд хамтран ажиллана. Оролцогч Талуудын бага хурлаас эдгээр зүйлүүдийн заалтуудыг хэрэгжүүлэх талаар зохих удирдамжуудыг санал болгоно.

8 дугаар зүйл

Тамхины утаанд нэрвэгдэх явдлаас хамгаалах

1. Оролцогч Талууд тамхины утаанд нэрвэгдэх явдал үхэл, өвчин, хөдөлмөрийн алдагдахад чадвар хүргэдгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоосныг хүлээн зөвшөөрч байна.
2. Ажлын байр, нийтийн тээвэр, олон нийтийн газрууд, мөн шаардлагатай тохиолдолд бусад олон нийтийн газруудад тамхины утаанд нэрвэгдэх явдлаас хамгаалах үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны ба/буюу бусад арга хэмжээнүүдийг үндэсний хуулиудад тодорхойлсноор үндэсний хэмжээний хууль зүйн хүрээнд хүлээн авч хэрэгжүүлж бусад хууль зүйн түвшинд эдгээр арга хэмжээнүүдийг идэвхтэй дэмжинэ.

9 дүгээр зүйл

Тамхин бүтээгдэхүүний найрлагыг зохицуулах

Оролцогч Талуудын Бага хурал бусад эрх бүхий олон улсын байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр тамхин бүтээгдэхүүний найрлага, тамхины утааг шинжлэх, хэмжих талаар мөн эдгээр утаа, найрлагын утааны зохицуулах удирдамжуудыг санал болгоно. Оролцогч Тал бүр энэхүү шинжилгээ, хэмжилтийн болон зохицуулалтын талаарх үндэсний эрх бүхий байгууллагуудын зөвшөөрч баталсны дагуу үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны буюу бусад арга хэмжээнүүдийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл

Тамхины бүтээгдэхүүний талаарх мэдээллийг зохицуулах

Оролцогч Тал бүр үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн тамхин бүтээгдэхүүний найрлага, гарах утааны талаарх мэдээллээр засгийн газрын байгууллагуудыг хангаж байхыг тамхины үйлдвэрлэгчид, импортлогчдоос шаардсан үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны буюу бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Оролцогч Тал бүр цаашид тамхин бүтээгдэхүүнүүдийн хортой бүрэлдэхүүн хэсэг болон гарч болох утааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж байх талаар үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл

Тамхин бүтээгдэхүүнийг савлах ба шошголох

1. Оролцогч Тал бүр тэдгээрийн хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ:
 - (а) бүх тамхин бүтээгдэхүүний сав, шошго нь тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэл, утааны талаар буруу, төөрөгдүүлсэн, хуурамч ойлголт өгөх зэргээр тамхин бүтээгдэхүүнийг сурталчлахгүй байх. Үүнд тухайн тамхин бүтээгдэхүүн бусад тамхин бүтээгдэхүүнээс бага хортой гэдэг буруу ойлголтыг шууд ба шууд бусаар өгөх аливаа нэр томъёо, тодорхойлолт, худалдааны тэмдэг, дүрслэлтэй буюу бусад хэлбэрийн тэмдэг орно. Энэхүү нэр томъёонд "бага бохьтой", "хөнгөн", "маш хөнгөн" буюу "зөөлөн" зэрэг орно;

- (б) тамхин бүтээгдэхүүний нэгж сав, хайрцаг бүр болон эдгээр төрлийн бүтээгдэхүүний гадна талын боодол, шошго нь тамхины хэрэглээнээс үүсэх хортой үр дагаврыг тайлбарласан эрүүл мэндийн анхааруулах бичиг болон бусад шаардлагатай бичигтэй байж болно. Эдгээр анхааруулга болон санамж бичгүүд нь:
- (i) үндэсний эрх бүхий байгууллагаас баталгаажсан байх,
 - (ii) үе үе солигддог байх,
 - (iii) том хэмжээний, тод, харагдахуйц, гаргацтай байх ёстой,
 - (iv) тамхины хайрцагны ил харагдах хэсгийн 50 ба түүнээс дээш хувийг эзэлсэн байх, харин 30-аас доошгүй хувийг эзлэх ёстой,
 - (v) зураг буюу дүрсээр харуулсан буюу тэдгээрийг агуулсан байж болно.
2. Тамхин бүтээгдэхүүний сав, хайрцаг бүр болон эдгээр төрлийн бүтээгдэхүүний гадна талын боодол, шошго дээр энэ зүйлийн 1(б) хэсэгт тодорхойлогдсон анхааруулах бичгүүдээс гадна үндэсний захиргааны байгууллагуудаас тогтоосон тамхин бүтээгдэхүүний найрлага, гарах утааны тухай мэдээллийг агуулсан байх ёстой.
3. Оролцогч Тал бүр энэ зүйлийн 1(б) ба 2 дахь хэсэгт заасан анхааруулах бичгүүд болон мэдээллийг тамхины бүтээгдэхүүний сав, хайрцаг бүр болон эдгээр төрлийн бүтээгдэхүүний гадна талын боодол, шошго дээр тухайн орны албан ёсны нэг буюу түүнээс дээш хэл дээр бичигдсэн байхыг шаардана.
4. Энэхүү зүйлийн зорилгоор тамхин бүтээгдэхүүнд хэрэглэж буй "гадна талын боодол, шошго" гэсэн нэр томъёог уг бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд ашиглагдаж буй аливаа сав, боодлын хувьд хэрэглэнэ.

12 дугаар зүйл

Боловсрол, олон нийтийн харилцаа, сургалт ба олон нийтийн ухамсар

Оролцогч Тал бүр олон нийтийн харилцааны бүх хэрэгслийг зохих ёсоор ашиглан тамхины хяналтын асуудлуудын талаарх олон нийтийн ухамсрыг дэмжиж бэхжүүлнэ. Энэ зорилтыг биелүүлэхэд Оролцогч Тал бүр үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны болон бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж доор дурдсан зүйлийг дэмжинэ:

- (а) тамхины хэрэглээний дасал үүсгэх шинж чанар болон тамхины утаанд нэрвэгдэх явдлаас үүдэн гарах эрүүл мэндийн эрсдэлийн талаар олон талыг хамарсан сурталчилгааны болон олон нийтийг ухамсарлуулах хөтөлбөрүүдийг өргөн хүртээмжтэй болгох;
- (б) тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдсэнээс үүдэн гарах эрүүл мэндийн эрсдэл, 14.2-т тодорхойлсон тамхинаас гарах болон тамхинаас ангид амьдрах амьдралын давуу Талуудын талаар олон нийтэд сурталчлах;
- (в) энэхүү Конвенцийн зорилготой холбогдуулан, үндэсний хууль тогтоомжийн дагуу тамхи үйлдвэрлэгчдийн тухай өргөн хүрээтэй мэдээлэл авах бололцоог олон нийтэд олгох;
- (г) эрүүл мэндийн ажилтан, нийгмийн ажилтан, хамт олны ажилтан, мэдээллийн хэрэгслийн боловсон хүчин, боловсролын ажилтан, шийдвэр гаргагчид, захиргааны ажилтан болон бусад холбогдох хүмүүст тамхины хяналтын талаарх үр дүнтэй, зохицсон сургалт, сэрэмжлүүлэх болон олон нийтийг ухамсарлуулах хөтөлбөрүүдийг зориулах;

- (д) тамхины хяналтын салбар хоорондын хөтөлбөрүүд болон стратегийг боловсруулж хэрэгжүүлэхэд тамхи үйлдвэрлэгчидтэй холбоогүй олон нийтийн ба хувийн агентлагууд, төрийн бус байгууллагуудыг татан Амин оролцуулах; болон
- (е) тамхины үйлдвэрлэл ба хэрэглээнээс гаралтай эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчны сөрөг үр дагаврын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, түүнийг хүртээмжтэй болгох.

13 дугаар зүйл

Тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх ба ивээн тэтгэх

1. Тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх ба ивээн тэтгэхэд бүрэн хориг тавих нь тамхины хэрэглээг бууруулж чадна гэдгийг Оролцогч Талууд хүлээн зөвшөөрч байна.
2. Оролцогч Тал бүр өөрийн Үндсэн хууль болон үндсэн хуулийн зарчмуудын дагуу тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх ба ивээн тэтгэх үйл ажиллагаанд бүрэн хориг тавина. Үүнд Оролцогч Талууд хууль зүйн орчин ба техникийн нөхцөл бололцооныхоо хирээр өөрийн нутаг дэвсгэрээс хил дамжуулан сурталчлах, дэмжлэг үзүүлэх ба ивээн тэтгэх үйл ажиллагаа явуулахыг хориглох арга хэмжээ авна. Энэ талаар Оролцогч Тал бүр тэдгээрийн хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн доторх хугацаанд шаардлагатай хууль зүй, гүйцэтгэх, захиргааны болон/буюу бусад арга хэмжээнүүдийг авч, энэ талаар 21 дүгээр зүйлд заасны дагуу тайлагнана.
3. Өөрийн Үндсэн хууль буюу үндсэн хуулийн зарчмуудаас шалтгаалан олон талын хориг тавих боломжгүй Оролцогч Тал нь тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэхэд хязгаарлалт тавина. Үүнд тухайн Оролцогч Талын хууль зүйн орчин ба техникийн нөхцөл бололцооны хирээр өөрийн орон нутгаас гаралтай хил дамжин нөлөөлөх зар сурталчилгаа, дэмжлэг ба ивээн тэтгэх явдалд хязгаарлалт хийх буюу бүрэн хориг тавих арга хэмжээ орно. Оролцогч Тал бүр шаардлагатай хууль зүй, гүйцэтгэх, захиргааны ба/буюу бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж 21 дүгээр зүйлд заасны дагуу тайлагнана.
4. Оролцогч Тал бүр өөрийн Үндсэн хууль буюу үндсэн хуулийн зарчмуудад нийцүүлэн наад зах нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - (а) тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэл, утааны талаарх буруу, төөрөгдүүлсэн, хуурамч ойлголт өгөх зэрэг аливаа хэрэгслээр тамхин бүтээгдэхүүнийг сурталчлах, дэмжих ба ивээн тэтгэх явдлын бүх хэлбэрийг хориглох;
 - (б) эрүүл мэндийн буюу бусад хэлбэрийн анхааруулга, мэдэгдлийг - тамхины зар сурталчилгааны бүх хэлбэр холбогдох ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаатай хавсарч явуулж байх;
 - (в) тамхин бүтээгдэхүүнийг олон нийтэд худалдаалахдаа шууд ба шууд бус замаар урамшуулал үзүүлэхийг хориглох;
 - (г) хэрэв тамхины зар сурталчилгааны иж бүрэн хоригийг хэрэгжүүлээгүй бол тамхи үйлдвэрлэгчдээс одоогоор хориглоогүй байгаа тамхины зар сурталчилгаа, дэмжлэг ба ивээн тэтгэлэгт зарцуулсан хөрөнгийн талаарх мэдээллийг засгийн газрын зохих захиргааны байгууллагуудад ирүүлэхийг шаардах. Эдгээр захиргааны байгууллагууд уг мэдээллийг 21 дүгээр зүйлд заасны дагуу олон нийт болон Оролцогч Талуудын бага хуралд нээлттэй болгох талаар шийдвэр гаргаж болно;

- (д) Оролцогч Тал нь таван жилийн хугацааны дотор радио, телевиз, хэвлэл болон боломжтой үед интернэт мэтийн олон нийтийн хэрэгслээр тамхийг сурталчлах, дэмжих ба ивээн тэтгэх бүх явдалд иж бүрэн хориг тавих буюу өөрийн Үндсэн хууль буюу үндсэн хуулийн зарчмуудаас болж иж бүрэн хориг тавих боломжгүй тохиолдолд хязгаарлалт тавих; ба
 - (е) Оролцогч Тал нь олон улсын үйл явдал, үйл ажиллагаа болон түүнд оролцогч Талуудыг тамхи үйлдвэрлэгчдээс ивээн тэтгэхэд хориг тавих буюу өөрийн Үндсэн хууль буюу үндсэн хуулийн зарчмуудаас болж хориг тавих боломжгүй тохиолдолд хязгаарлалт тавина.
5. Оролцогч Талууд гуравдугаар зүйлд заасан үүргүүдээс гадна бусад арга хэмжээ авахыг дэмжиж байна.
 6. Оролцогч Талууд хил дамжсан зар сурталчилгааг устгахад туслах технологи болон бусад арга хэрэгслийг боловсруулахад хамтран ажиллана.
 7. Тамхийг сурталчлах, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэхэд тодорхой хэлбэрийн хоригтой байгаа Оролцогч Талууд тэдгээрийн нутаг дэвсгэрт орж ирж буй хил дамжсан зар сурталчилгаа, ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх явдлыг хориглох тусгаар тогтносон эрхтэй байх ба үндэсний хууль тогтоомжид нийцсэн өөрийн нутаг дэвсгэрээс гаралтай зар сурталчилгаа, ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд адил хэмжээний шийтгэл ногдуулах эрхтэй. Энэ зүйл нь ямар нэгэн тодорхой шийтгэлийг дэмжих буюу баталгаажуулахгүй.
 8. Оролцогч Талууд хил дамжсан зар сурталчилгаа, ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд иж бүрэн хориг тавихад олон улсын хамтын ажиллагааг шаардсан зохих арга хэмжээнүүдийг боловсруулах протоколыг байгуулах талаар санаа тавина.

14 дүгээр зүйл

Тамхины дасал ба тамхинаас гарахад хамаарах тамхины эрэлт хэрэгцээг бууруулах арга хэмжээ

1. Оролцогч Тал бүр тамхинаас гарах явдлыг дэмжих ба тамхины хамаарлыг эмчлэх үр дүнтэй арга хэмжээ авч үндэсний нөхцөл байдал, тэргүүлэх зорилтуудыг харгалзан шинжлэх ухааны нотолгоо, оновчтой арга барил дээр үндэслэсэн тохирсон, иж бүрэн, харилцан уялдуулсан удирдамжуудыг боловсруулж түгээнэ.
2. Энэ зорилтыг биелүүлэх үүднээс Оролцогч Тал бүр дараах арга хэмжээг биелүүлэхэд хүчин чармайлт тавина:
 - (а) боловсрол, эрүүл мэндийн байгууллага, ажлын байр, спортын орчин зэрэг газруудад тамхинаас гарах явдлыг дэмжих үр дүнтэй хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;
 - (б) үндэсний эрүүл мэнд ба боловсролын хөтөлбөр, төлөвлөгөө, стратегиудад тамхины хамаарлын оношилгоо, эмчилгээ ба тамхинаас гарах зөвлөгөө өгөх үйлчилгээг оруулж үүнд нөхцөл байдалд тохируулан эрүүл мэндийн ажилтан, хамт олны болон нийгмийн ажилтнуудыг оролцуулах;
 - (в) эрүүл мэндийн байгууллага болон сэргээн засах төвүүдэд тамхины хамаарлыг оношлох, зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх, эмчлэх хөтөлбөрүүдийг нэвтрүүлж ажиллуулах; ба
 - (г) 22 дугаар зүйлд заасан тамхины хамаарлын эмчилгээ болон эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нээлттэй, худалдаж авах бололцоотой 1 болгох

талаар бусад Оролцогч Талуудтай хамтран ажиллах. Эдгээр бүтээгдэхүүн болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд эмийн бэлдмэл, эмийг өвчтөнд хэрэглэхэд зориулсан хэрэгсэл болон оношилгооны хэрэгсэл зэрэг орно.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ТАМХИНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХЯЗГААРЛАХТАЙ ХОЛБООТОЙ АРГА ХЭМЖЭЭ

15 дугаар зүйл

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа

1. Оролцогч Талууд тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа, үйлдвэрлэл, хуурамч үйлдвэрлэл зэрэг хууль бус худалдааны бүх хэлбэрийг устгах, дэд бүс нутгийн, бүс нутгийн ба олон улсын хэлэлцээрээс гадна зохих үндэсний хууль тогтоомжийг боловсруулж хэрэгжүүлэх нь тамхины хяналтын салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
2. Тамхин бүтээгдэхүүний гарал үүслийг Оролцогч Талуудад тодорхойлоход туслах зорилгоор тамхины бүтээгдэхүүний сав боодлын нэгж, хайрцаг бүр болон эдгээр бүтээгдэхүүний гадна талын боодол дээр тэмдэг тавих талаар Оролцогч Тал бүр хууль зүй, гүйцэтгэх, захиргааны болон бусад арга хэмжээнүүдийг хүлээн авч хэрэгжүүлэх бөгөөд үндэсний хууль тогтоомж, хоёр ба олон талын гэрээнүүдийн дагуу Оролцогч Талуудад тамхин бүтээгдэхүүний хөдөлгөөнийг тандах, баримтжуулах, хянах ба тэдгээрийн хууль зүйн байдлыг тодорхойлох, чиглэл өөрчлөх цэгийг тодорхойлоход туслах. Үүнээс гадна Оролцогч Тал бүр:
 - (а) дотоодын зах зээл дээр жижиглэнгийн болон бөөний худалдаанд зориулсан тамхин бүтээгдэхүүний сав боодлын нэгж, хайрцаг дээр "Зөвхөн (орны нэр, орон нутгийн, бүс нутгийн, холбооны улсын нэрийг оруулах)-д худалдахыг зөвшөөрнө" гэсэн бичиг тавихыг шаардах буюу худалдааны эцсийн цэгийг заасан бичиглэл, буюу уг бүтээгдэхүүн зах зээл дээр хууль ёсоор зарагдаж байгаа эсэхийг захиргааны байгууллагуудад тодорхойлоход туслах бусад бичиг тавихыг шаардана;
 - (б) тамхины түгээх тогтоолцоог бололцоотой бол бэхжүүлэх, хууль бус худалдааг мөрдөхөд туслах практикийн мөрдөх тогтолцоог боловсруулах талаар анхаарал тавих.
3. Оролцогч Тал бүр энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан сав боодлын мэдээлэл буюу тэмдэг нь гаргацтай байх ба/буюу албан ёсны нэг буюу түүнээс дээш тооны хэл дээр бичигдсэн байхыг шаардана.
4. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах зорилгын үүднээс Оролцогч Тал бүр:
 - (а) хил дамжсан тамхины худалдаа болон хууль бус худалдааны талаар мэдээлэл цуглуулж хяналт тавих, ба нөхцөл байдал, үндэсний хууль тогтоомж, хоёр ба олон талын гэрээнүүдийн дагуу гааль, татвар болон бусад захиргааны байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох;
 - (б) хуурамчаар үйлдэж хууль бусаар борлуулсан тамхи зэрэг болон тамхин бүтээгдэхүүний хууль бус бусад хэлбэрийн худалдааны эсрэг зохих шийтгэх, залруулах арга хэмжээнүүдийг оролцуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх буюу батжуулах;

- (в) хураагдсан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хуурамчаар үйлдсэн ба хууль бусаар борлуулсан тамхи болон бусад тамхин бүтээгдэхүүнийг бололцоотой үед байгаль орчинд хор нөлөө учруулахгүйгээр буюу үндэсний хууль тогтоомжийн дагуу устгасан байх талаар арга хэмжээ авах;
 - (г) өөрийн хууль тогтоомжийн хүрээнд татвар буюу гаалийн татвар төлөөгүй байгаа тамхин бүтээгдэхүүний хадгалалт ба түгээлтийг тандах, баримтжуулах, хянах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх; ба
 - (д) тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаанаас олсон орлогыг хураах явдлыг боломжтой болгох талаар арга хэмжээг бололцоотой үед авах.
5. Оролцогч Талууд нь энэ зүйлийн 4 (а) болон 4 (г) дэд хэсэгт заасны дагуу цуглуулсан мэдээллийг бололцоотой үед Оролцогч Талуудын Бага хуралд хураангуй хэлбэрээр тогтмол тайлангаар 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлнэ.
6. Оролцогч Талууд тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах зорилгоор хийгдэж буй мөрдөн байцаалт, шийтгэл болон шүүх хурлыг явуулахад бололцоотой үед ба үндэсний хууль тогтоомжийн дагуу үндэсний агентлагууд, зохих бүс нутгийн ба олон улсын засгийн газар хоорондын байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ. Тамхины бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэхэд бүс нутгийн ба дэд бүс нутгийн хамтын ажиллагаанд онцгой анхаарал тавих болно.
7. Оролцогч Тал бүр хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх үүднээс тамхин бүтээгдэхүүний худалдаа, түгээлтийг (тусгай зөвшөөрлийг оролцуулан) зохицуулах буюу хянах зорилгоор тухайн нөхцөл байдалд тохируулан цаашдын арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гаргана.

16 дугаар зүйл

Насанд хүрээгүй хүнд тамхи худалдах болон насанд хүрээгүй хүнээр тамхи худалдуулах

1. Оролцогч Тал бүр үндэсний хууль тогтоомжоор заасан насанд хүрээгүй хүн буюу 18 нас хүрээгүй хүнд тамхин бүтээгдэхүүн худалдаалахыг хориглох талаар засгийн газрын зохих түвшинд үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны буюу бусад арга хэмжээнүүдийг хүлээн авч хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээнүүдэд доор дурдсан зүйлс орж болно:
- (а) тамхин бүтээгдэхүүн худалдаалж буй бүх худалдаачид, худалдаа хийж буй газарт насанд хүрээгүй хүнд тамхи зарахыг хориглосон ил, харагдахуйц тэмдэг тавих ба эргэлзээтэй үед тамхи худалдаж авч буй хүн бүр насанд хүрсний хууль ёсны баталгааг гаргаж ирэхийг шаардах;
 - (б) өөрөө өөртөө үйлчлэх дэлгүүр зэрэг тамхин бүтээгдэхүүнийг ямарваа нэг хэлбэрээр хүн өөрөө авч болох хэлбэрээр худалдаалахыг хориглох;
 - (в) насанд хүрээгүй хүний анхаарлыг татахуйц тамхин бүтээгдэхүүний хэлбэрээр хийгдсэн чихэр, хөнгөн зууш, тоглоом буюу өөр ямар нэг зүйлийг үйлдвэрлэж худалдаалахыг хориглох;
 - (г) тамхи зарах автомат машин нь насанд хүрээгүй хүнд нээлттэй бус байх ба насанд хүрээгүй хүнд тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх;
2. Оролцогч Тал бүр олон нийтэд, ялангуяа насанд хүрээгүй хүнд тамхин бүтээгдэхүүнийг үнэгүй тараахыг хориглох буюу хориглохыг дэмжинэ.

3. Оролцогч Тал бүр насанд хүрээгүй хүнийг тамхин бүтээгдэхүүнд хүрэх бололцоо олгодог ширхэгээр буюу цөөн ширхэгээр савласан янжуур зарахыг хориглох талаар хүчин чармайлт тавина.
4. Насанд хүрээгүй хүн тамхин бүтээгдэхүүн борлуулах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд эдгээр арга хэмжээг бололцоотой үед энэхүү Конвенцид агуулагдаж буй бусад заалтуудтай хамт хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
5. Энэхүү Конвенцид гарын үсэг зурах, түүнийг батлах, хүлээн авах, зөвшөөрөх буюу батлах үед болон түүний дараах үед Оролцогч Тал бичгийн хэлбэрээр гаргасан, хүчин төгөлдөр мэдэгдэл гаргаж өөрийн хууль зүйн хүрээнд тамхи зарах автомат машин оруулахаас татгалзах буюу, бололцоотой үед бүрмөсөн хориглож байгаагаа илэрхийлж болно. Энэ бүлгийг биелүүлэх үүднээс гаргасан мэдэгдлийг Гаргагч Тал энэхүү Конвенцийн бүх Оролцогч Талуудад тараана.
6. Оролцогч Тал бүр энэ зүйлийн 1-5 дахь хэсэгт заасан үүргийн биелэлтийг хангах зорилгоор тамхийг борлуулагч ба түгээгчдийн эсрэг авах шийтгэлийг оролцуулан үр дүнтэй хууль зүй, гүйцэтгэх, захиргааны буюу бусад арга хэмжээнүүдийг хүлээн авч хэрэгжүүлнэ.
7. Оролцогч Тал бүр дотоодын, үндэсний хуульд зааснаар насанд хүрээгүй буюу 18-аас доош насны хүнээр тамхин бүтээгдэхүүн борлуулахыг хориглох талаар үр дүнтэй хууль зүйн, гүйцэтгэх, захиргааны буюу бусад зохих арга хэмжээнүүдийг батлан хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл

Эдийн засгийн хувьд ашигтай өөр үйл ажиллагаанд шилжихийг дэмжих

Оролцогч Талууд өөр хоорондоо болон олон улс, бүс нутгийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж бололцоотой үед тамхины үйлдвэрлэлийн ажилчид, тариаланчид мөн зарим нөхцөлд тухайн бие даасан борлуулагчийг өөр эдийн засгийн хувьд ашигтай хувилбарт шилжихийг дэмжинэ.

ТАВДУГААР ХЭСЭГ: БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ

18 дугаар зүйл

Байгаль орчин, хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах

Энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргийн биелүүлэх явцад Оролцогч Талууд тэдгээрийн нутаг дэвсгэр дээр оршиж буй тамхины тариалан болон үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчны хувьд түүний болон хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах талаар зохих анхаарал тавих талаар зөвшилцөв.

ЗУРГААДУГААР ХЭСЭГ: ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ АСУУДЛУУД

19 дүгээр зүйл

Хариуцлага

1. Тамхинд хяналт тавих зорилгоор Оролцогч Талууд эрүүгийн болон иргэний хариуцлагын харилцааг зохицуулах, шаардлагатай үед хохирлыг төлүүлэх талаар хуулийн арга хэмжээ авах буюу оршиж буй хуулийг дэмжих талаар анхаарал тавина.
2. 21 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч Талууд нь Оролцогч Талуудын Бага хурлаар дамжуулан хоорондоо мэдээлэл солилцох талаар хамтран ажиллах бөгөөд үүнд доор дурдсан мэдээлэл орно:
 - (а) 20.3 (а) дугаар зүйлийн заалтын дагуу тамхин бүтээгдэхүүний хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдсэнээс үүдэлтэй эрүүл мэндийн үр нөлөөний талаарх мэдээлэл;
 - (б) үйлчилж буй хууль тогтоомж, дүрэм болон хамаарах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл.
3. Оролцогч Талууд энэхүү Конвенцтой нийцэж буй иргэний болон эрүүгийн хариуцлагатай холбоотой шүүн таслах ажиллагаанд үндэсний хууль тогтоомж, бодлого, хуулийн практик болон хэрэглэгдэж буй хэлэлцээрийн нөхцөлийн хүрээнд бие биедээ тусламж дэмжлэг үзүүлэх талаар харилцан зөвшилцсөн болно.
4. Энэхүү Конвенц нь Оролцогч Талуудын урд өмнө тогтоосон шүүх хоорондын харилцааны эрхийг ямар ч хэлбэрээр хөндөх буюу хязгаарлахгүй.
5. Оролцогч Талуудын Бага хурал энэхүү зүйлд заасан хууль зүйн болон бусад үйл ажиллагаанд Оролцогч Талуудыг аль болох эрт үе шатанд нь тэдний хүсэлтийн үндсэн дээр зохих хэрэгслийг ашиглан дэмжих талаар анхаарч болно. Үүнд зохих олон улсын орчинд хийгдэж буй ажил, хариуцлагын талаарх асуудлуудыг олон улсын хүрээнд хэрхэн авч үзэж байгаа байдал зэргийг харгалзан үзнэ.

ДОЛООДУГААР ХЭСЭГ: ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

20 дугаар зүйл

Судалгаа, тандалт ба мэдээлэл солилцох

1. Оролцогч Талууд тамхины хяналтын салбарт үндэсний эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэн дэмжих, ба бүс нутаг, олон улсын түвшинд эрдэм шинжилгээний хөтөлбөрүүдийг нийцүүлэх талаар үүрэг авч байна. Үүний тулд Оролцогч Тал бүр:
 - (а) эрдэм шинжилгээний судалгаа болон шинжлэх ухааны үнэлгээг явуулах ажлыг эхлүүлэх болон энэ талаар шууд буюу эрх бүхий - олон улсын ба бүс нутгийн засгийн газар хоорондын болон бусад байгууллагуудаар дамжуулан хамтран ажиллаж тамхины хэрэглээ болон тамхины утаанд нэрвэгдэх явдлыг тодорхойлох хүчин зүйлс, үр дагаврын сэдвээр хийгдэх судалгаа, тамхийг орлуулах ургамлыг тодорхойлох судалгааны ажлыг дэмжих; ба

- (б) тамхины хяналтын үйл ажиллагаа болон судалгаа, хэрэгжүүлэх ба үнэлэх ажилд оролцож буй хүмүүсийг сургах, дэмжлэг үзүүлэх ажлыг эрх бүхий олон улсын ба бүс нутгийн засгийн газар хоорондын болон бусад байгууллагуудын тусламжтайгаар дэмжин батжуулах.
2. Оролцогч Талууд тамхины хэрэглээ, тамхины утаанд нэрвэгдэх явдлын хүрээ, зүй тогтол, тодорхойлох хүчин зүйл, үр дагаврыг тандаж судлах үндэсний, бүс нутгийн болон дэлхий хэмжээний хөтөлбөрүүдийг буй болгоно. Энэ зорилтыг биелүүлэх үүднээс Оролцогч Талууд тамхины тандалт судалгааны хөтөлбөрүүдийг үндэсний, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний эрүүл мэндийн тандалт судалгааны хөтөлбөрүүдтэй нэгтгэж тэдгээрийн мэдээллийг харьцуулан судлах боломж олгож мэдээллийг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд дүгнэхэд боломжтой болгоно.
3. Оролцогч Талууд олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын болон бусад байгууллагуудаас санхүү, техникийн дэмжлэг үзүүлэхийн чухлыг хүлээн зөвшөөрч байна. Үүний тулд Оролцогч Тал бүр дараах арга хэмжээг биелүүлэхэд хүчин чармайлт тавина:
- (а) тамхины хэрэглээ болон түүнтэй холбоотой нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн тархвар судлалын тандалтын үндэсний хэмжээний тогтолцоог буй болгох;
- (б) бүс нутгийн болон дэлхийн хэмжээний тамхины тандалт, энэ зүйлийн 3(а) дэд хэсэгт заасан үзүүлэлтүүдийн талаарх мэдээлэл солилцох талаар эрх бүхий олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын, засгийн газрын ба төрийн бус байгууллагуудыг оролцуулсан бусад байгууллагуудтай хамтран ажиллах; ба
- (в) тамхины холбогдолтой тандалтын мэдээлэл цуглуулах, задлан шинжлэх, түгээх зэргийг тодорхойлсон ерөнхий удирдамж бичиг буюу журам боловсруулах талаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагатай хамтран ажиллах.
4. Оролцогч Талууд үндэсний хууль тогтоомжийн хүрээнд мөн энэхүү Конвенцийн зорилгод нийцсэн тамхи үйлдвэрлэгчдийн нийтлэг үйл ажиллагаа болон тамхины тариалангийн ажлын талаарх мэдээлэл, олон нийтэд нээлттэй шинжлэх ухаан, техник, нийгэм эдийн засгийн, бизнесийн болон хууль зүйн мэдээллийн солилцоог дэмжиж туслах бөгөөд үүнийгээ гүйцэтгэхдээ хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудын тусгай хэрэгцээг харгалзан үзнэ. Үүний тулд Оролцогч Тал бүр дараах арга хэмжээг биелүүлэхэд хүчин чармайлт тавина:
- (а) тамхины хяналтын талаарх хууль, дүрэм, бололцоотой үед тэдгээрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, мөн нийцэх хууль тогтоомжийн тухай шинэчилсэн мэдээллийн санг үе шаттайгаар байгуулах, хадгалах, бүс нутаг, дэлхийн хэмжээний тамхины хяналтын хөтөлбөрүүдийг боловсруулахад хамтран ажиллах;
- (б) энэ зүйлийн 3(а) хэсэгт заасны дагуу үндэсний тандалтын хөтөлбөрүүдээс олсон шинэчлэгдсэн мэдээллийг үе шаттайгаар байгуулах, хадгалах;
- (в) энэхүү Конвенц буюу үндэсний тамхины хяналтын үйл ажиллагаанд нөлөөлөх тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа, тамхины үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулах ба тараах дэлхийн хэмжээний тогтолцоог байгуулах, түүнийг байлгах талаар эрх бүхий олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;
5. Оролцогч Талууд тэдгээрийн гишүүн болсон бүс нутгийн ба олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд, санхүү, хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж Нарийн Бичгийн Газрыг техник, санхүүгийн эх үүсвэрээр хангахыг дэмжин сайшааж, хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч

Талуудад тэдгээрийн судалгаа, тандалт, мэдээлэл солилцох талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тусална.

21 дүгээр зүйл

Тайлагнах ба мэдээлэл солилцох

1. Оролцогч Тал бүр Нарийн Бичгийн Газраар дамжуулан Оролцогч Талуудын Бага хуралд энэхүү Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлан тавих бөгөөд үүнд дор дурдсан зүйлийг оруулна:
 - (а) энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх талаар авсан хууль зүй, гүйцэтгэх, захиргааны буюу бусад арга хэмжээ;
 - (б) энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх явцад гарч ирсэн аливаа саад тотгорын талаарх мэдээлэл болон эдгээр саадыг даван туулах талаар авсан арга хэмжээ;
 - (в) тамхины хяналтын үйл ажиллагаанд олгосон буюу хүлээн авсан санхүү, техникийн туслалцааны талаарх мэдээлэл;
 - (г) 20 дугаар зүйлд заасан тандалт ба судалгааны талаарх мэдээлэл; ба
 - (д) 6.3, 13.2, 13.3, 13.4(г), 15.5 ба 19.2 дугаар зүйлүүдэд заасан мэдээлэл.
2. Бүх Оролцогч Талуудаас ирүүлэх тайлангуудын давтамж, хэлбэрийг Оролцогч Талуудын Бага хурлаас шийдвэрлэнэ. Оролцогч Тал бүр уг Конвенцид нэгдэн орсноос хойш 2 жилийн дотор эхний тайлангаа ирүүлнэ.
3. 22 ба 26 дугаар зүйлийн дагуу Оролцогч Талуудын Бага хурал хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудаас гаргасан хүсэлтээр энэ зүйлийн дагуу хүлээсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай тусламж үзүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахыг харгалзаж үзнэ.
4. Энэхүү Конвенцийн дагуу явагдах тайлагнах ба мэдээлэл солилцох үйл явц нь нууцлал болон хувийн нууц хадгалах талаар үндэсний хуулиудын үйлчлэх хүрээнд явагдана. Оролцогч Талууд хамтарч тохиролцсоны үндсэн дээр мэдээллийн нууцлалыг хамгаална.

22 дугаар зүйл

Шинжлэх ухаан, техник ба хууль зүйн хүрээний хамтын ажиллагаа ба холбогдох экспертиз явуулах

1. Оролцогч Талууд энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх үүднээс үүсч буй үүргийг биелүүлэх талаар эрх бүхий олон улсын байгууллагуудтай шууд буюу тэдгээрээр дамжуулан хамтарч ажиллах бөгөөд хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудын хэрэгцээг харгалзан үзнэ. Энэхүү хамтын ажиллагаа техник, шинжлэх ухаан, хууль зүйн туршлага технологийг дамжуулахыг дэмжих бөгөөд энэ нь харилцан тохиролцсоны үндсэн дээр тамхины хяналтын талаар үндэсний стратеги, төлөвлөгөө, хөтөлбөртэй болох, тэдгээрийг бэхжүүлэх ба бусад зүйлийн зэрэгцээ доор дурдсан зүйлүүдэд чиглэсэн байна:
 - (а) тамхины хяналтад хамаарах технологи, мэдлэг, чадвар, хүчин чадал ба мэргэжлийн туршлага зэргийг хөгжүүлэх, дамжуулах болон авахад туслалцаа үзүүлэх;

- (б) энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний тамхины хяналтын стратеги, төлөвлөгөө, хөтөлбөртэй болох, тэдгээрийг бэхжүүлэхэд шинжлэх ухаан, техник, хууль зүйн ба бусад төрлийн мэргэжлийн туршлагаар хангахын тулд бусад зүйлийн зэрэгцээ доор дурдсан арга хэмжээ авна:
 - (i) хүсэлт гаргасны үндсэн дээр тамхинд орохоос сэргийлэх, тамхинаас гарахыг дэмжих, тамхины утаанд нэрвэгдэхээс хамгаалах зэргийг багтаасан техникийн хөтөлбөрүүд болон хүчтэй хууль зүйн үндэс суурийг боловсруулахад туслах;
 - (ii) бололцооны хирээр тамхины үйлдвэрлэлийн ажилчдад тамхийг орлуулах эдийн засгийн хувьд ашигтай болон хууль зүйн талаас хүчин төгөлдөр амьдралын өөр эх үүсвэр хөгжүүлэхэд туслах;
 - (iii) бололцооны хирээр тамхи тариалагчдад тамхины оронд өөр ургамал тариалахад нь эдийн засгийн хувьд ашигтай хэлбэрээр туслах;
 - (в) 12 дугаар зүйлд заасны дагуу холбогдох боловсон хүчинд зориулсан сургалтын болон мэдээллийн зохих хөтөлбөрүүдийг дэмжих;
 - (г) тамхины хяналтын стратеги, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр хангах, дэмжлэг үзүүлэх;
 - (д) никотины хамаарлын иж бүрэн эмчилгээг оролцуулаад тамхины хяналтын арга хэмжээг тодорхойлох; ба
 - (е) никотины хамаарлын иж бүрэн эмчилгээг хямд болгох боломжийг нэмэгдүүлэх талаар судалгаа явуулахыг дэмжих.
2. Оролцогч Талуудын Бага хурал 26 дугаар зүйлийн дагуу баталгаажуулсан санхүүгийн дэмжлэгтэйгээр техник, шинжлэх ухаан, хууль зүйн туршлага технологийг дамжуулахыг дэмжиж гүйцэтгэнэ.

НАЙМДУГААР ХЭСЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ БА САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

23 дугаар зүйл

Оролцогч Талуудын Бага хурал

1. Оролцогч Талуудын Бага хурлыг ийнхүү байгуулав. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор Бага хурлын анхны хуралдааныг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага зохион байгуулна. Бага хурал анхны хуралдаан дээрээ цаашдын тогтмол хурлуудын зохион байгуулах газар, хугацааг тодорхойлно.
2. Оролцогч Талуудын Бага хурлын ээлжит бус хурлыг Бага хурлаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хуралдуулах буюу аль нэг Оролцогч Тал өргөдөл гаргаж бичгээр ирүүлсний дараа түүнийг бусад Талуудад Конвенцийн Нарийн Бичгийн Дарга Нарын Газар 6 сарын дотор бичгээр мэдэгдэж энэ өргөдлийг хамгийн бага гэхэд Оролцогч Талууд гуравны нэгээс дээш хувь дэмжсэн байх тохиолдолд хуралдуулна.
3. Оролцогч Талуудын Бага хурал анхны хуралдаан дээрээ Үйл Ажиллагааныхаа Дүрмийг Талуудын зөвшөөрсний үндсэн дээр батална.
4. Оролцогч Талуудын Бага хурал зөвшилцсөний үндсэн дээр өөрийн болон байгуулж болох харьяа байгууллагуудын санхүүгийн дүрэм болон Нарийн Бичгийн Газрын

үйл ажиллагааг удирдах санхүүгийн зүйл ангиудыг батална. Ээлжит хуралдаан дээр дараагийн ээлжит хуралдаан хүртэлх төсвийг батална.

5. Оролцогч Талуудын Бага хурал нь Конвенцийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг дэмжсэн шийдвэр гаргаж 28, 29 болон 33 дугаар зүйлийн дагуу Конвенцийн дагалдах протокол, хавсралт, Нэмэлт өөрчлөлтийг баталж болно. Энэ зорилгын үүднээс дараах арга хэмжээг авна:
 - (а) 20 болон 21 дүгээр зүйлийн заалтуудын дагуу мэдээллийн солилцоог дэмжиж туслах;
 - (б) Конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, 20 дугаар зүйлд заасан зүйлээс гадна судалгаа мэдээлэл цуглуулах, арга барилыг боловсруулах, түүнийг байнга төгөлдөржүүлэх ажлыг удирдаж дэмжих;
 - (в) стратеги, төлөвлөгөө, хөтөлбөрүүд болон бодлого, хууль тогтоомж ба бусад арга хэмжээнүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ өгөх явдлыг боллоцоотой үед дэмжих;
 - (г) 21 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч Талуудаас ирүүлсэн тайлангуудыг хянаж Конвенцийн хэрэгжилтийн талаарх тогтмол тайлангуудыг батлах;
 - (д) Конвенцийн хэрэгжилтийг хангах зорилгоор 21 дүгээр зүйлд заасны дагуу санхүүгийн эх үүсвэрүүдийг дайчлах асуудлыг дэмжин туслах;
 - (е) Конвенцийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай харьяа байгууллагуудыг зохион байгуулах;
 - (ё) Конвенцийн хэрэгжилтийг батжуулах зорилгоор Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтолцооны эрх бүхий болон хамааралтай байгууллагууд ба бусад олон улсын, бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллага, төрийн бус байгууллагуудаас хамтын ажиллагаа, үйлчилгээ, мэдээллээр хангаж байхыг хүсэх; ба
 - (ж) Конвенцийн хэрэгжилтийн явцад олж авсан туршлага дээр тулгуурлан Конвенцийн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай бусад төрлийн арга хэмжээ авах талаар санал дэвшүүлэх.
6. Оролцогч Талуудын Бага хурал өөрийнхөө үйл ажиллагаанд хөндлөнгийн ажиглагчдыг оролцуулах талаар шалгуур үзүүлэлтүүдийг гаргана.

24 дүгээр зүйл

Нарийн Бичгийн Дарга Нарын Газар

1. Оролцогч Талуудын Бага хурал байнгын Нарийн Бичгийн Дарга Нарын Газрыг томилж түүний үйл ажиллагааны талаар зохион байгуулалтын арга хэмжээ авна. Оролцогч Талуудын Бага хурал үүнийг анхны хуралдаан дээрээ шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргана.
2. Байнгын Нарийн Бичгийн Дарга Нарын Газрыг томилохоос өмнө энэхүү Конвенцийн Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын үйл ажиллагааг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гүйцэтгэнэ.
3. Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын үүрэг:
 - (а) Оролцогч Талуудын Бага хурал болон ямар нэгэн харьяа байгууллагуудын хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийх, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх;
 - (б) Конвенцийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн тайлангуудыг дамжуулах;

- (в) Оролцогч Талууд ялангуяа хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудад Конвенцийн заалтуудын дагуу хүсэх мэдээлэл цуглуулах, дамжуулах явдалд хүсэлтийнх нь дагуу дэмжлэг үзүүлэх;
- (г) Конвенцийн дагуу явуулах үйл ажиллагааны тайлангуудыг Оролцогч Талуудын Бага хурлын удирдлагын дор бэлтгэж, тэдгээрийг Оролцогч Талуудын Бага хуралд ирүүлэх;
- (д) Оролцогч Талуудын Бага хурлын удирдлагын дор эрх бүхий олон улсын байгууллага, бүс нутгийн засгийн газар хоорондын болон бусад байгууллагуудтай шаардлагатай зохицуулалтаар хангах;
- (е) Оролцогч Талуудын Бага хурлын удирдлагын дор түүний үйл ажиллагааг амжилттай явуулахад шаардлагатай захиргааны буюу гэрээлэх асуудлыг зохион байгуулах; болон
- (ё) Конвенц болон түүний ямар нэг протоколуудад заасан бусад Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын үүрэг болон Оролцогч Талуудын Бага хурлаас тогтоож болох энэ төрлийн бусад үүргийг хэрэгжүүлэх.

25 дугаар зүйл

Оролцогч Талуудын Бага хурал ба засгийн газар хоорондын байгууллагуудын хоорондын харилцаа

Энэхүү Конвенцийн зорилгыг биелүүлэхэд шаардагдах техник, санхүүгийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Оролцогч Талуудын Бага хурал нь санхүү, хөгжлийн байгууллагууд зэрэг эрх бүхий олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагуудын хамтын ажиллагааг хүсэж болно.

26 дугаар зүйл

Санхүүгийн эх үүсвэр

1. Оролцогч Талууд энэхүү Конвенцийн зорилгыг биелүүлэхэд санхүүгийн эх үүсвэр чухал ач холбогдолтой байгааг хүлээн зөвшөөрч байна.
2. Оролцогч Тал бүр өөрийн үндэсний төлөвлөгөө, тэргүүлэх зорилт, хөтөлбөрүүдийн дагуу энэхүү Конвенцийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн үндэсний хэмжээний үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
3. Оролцогч Талууд хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудын олон салбарыг хамарсан тамхины хяналтын иж бүрэн хөтөлбөрүүдийг боловсруулах, батжуулахад хэрэгцээтэй санхүүжилтээр хангах зорилгоор хоёр Талын, бүс нутгийн, дэд бүс нутгийн болон бусад олон талын сувгуудыг ашиглахыг дэмжинэ. Үүний дагуу үндэсний хэмжээнд боловсруулсан тогтвортой хөгжлийн стратегиудын хүрээнд тамхины үйлдвэрлэлийг эдийн засгийн хувьд ашигтай орлуулах хэлбэрүүд, тухайлбал өөр төрлийн ургамал тариалахад анхаарлаа хандуулж дэмжих хэрэгтэй.
4. Зохих бүс нутгийн, олон улсын засгийн газар хоорондын, санхүүгийн болон хөгжлийн байгууллагуудад төлөөлөлтэй Оролцогч Талууд эдгээр байгууллагуудыг хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудад энэхүү Конвенцийн дагуу гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг дэмжих бөгөөд энэ нь Эдгээр байгууллагуудад оролцох эрхийг хязгаарлахгүй.

5. Оролцогч Талууд дараах зүйлийг хүлээн зөвшөөрч байна:
- (a) Оролцогч Талуудад энэхүү Конвенцийн дагуу гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэхэд тусалж, бүх Оролцогч Талууд, ялангуяа хөгжиж буй 1 болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудын тусын тулд тамхины хяналтад зориулсан хамааралтай, байж болох болон байгаа олон нийтийн ба хувийн хэвшлийн санхүү, техникийн болон бусад эх үүсвэрийг дайчилж хэрэглэх;
 - (б) Нарийн Бичгийн Дарга Нарын Газар нь хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудад энэхүү Конвенцийн дагуу гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэхэд туслах санхүүгийн байгаа бүх эх үүсвэрийн талаар мэдээлнэ;
 - (в) Оролцогч Талуудын Бага хурал анхны хуралдаан дээрээ Нарийн Бичгийн Дарга Нарын Газраас явуулсан судалгаа болон бусад хамааралтай мэдээллийг үндэслэн байгаа болон байж болох санхүүгийн эх үүсвэр, тусламжийн механизмуудыг хянан хэлэлцэж тэдгээрийн таарч тохирох эсэхийг хэлэлцэх; ба
 - (ё) энэ тойм судалгааны үр дүнг Оролцогч Талуудын Бага хурал авч - хэлэлцэж, хөгжиж буй болон эдийн засгийн шилжилтийн үед буй Оролцогч Талуудад энэхүү Конвенцийн дагуу гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэхэд туслах зорилгоор одоо байгаа механизмуудыг хүчтэй болгох, сайн дурын дэлхийн хэмжээний сан байгуулах буюу санхүүгийн бусад зохих механизмуудыг байгуулж, шаардлагатай үед нэмэлт санхүүгийн эх үүсвэрүүдийг гаргаж өгөх зэрэг зүйлийг хийх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох.

ЕСДҮГЭЭР ХЭСЭГ: МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

27 дугаар зүйл

Маргааныг шийдвэрлэх

1. Хэрэв хоёр буюу түүнээс дээш Оролцогч Талуудын хооронд энэхүү Конвенцийг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбоотой маргаан гарвал, Оролцогч Талууд дипломат сувгуудыг ашиглан маргааныг тэдгээрийн сонгосон хэлэлцээний замаар буюу аливаа бусад энх тайвны аргаар түүний дотор сайн санааны элч, зуучлал эсхүл эвлэрүүлэх зэрэг аргаар шийдвэрлэх талаар ажиллана. Сайн санааны элч, зуучлал эсхүл эвлэрүүлэх зэргээр тохиролцоонд хүрэхгүй бол энэ нь маргаанд оролцож буй Оролцогч Талуудыг маргааныг шийдвэрлэх хариуцлагаас чөлөөлөхгүй.
2. Энэхүү Конвенцид соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, албан ёсоор баталгаажуулах буюу зөвшөөрч байгаа тохиолдолд буюу түүнээс хойш бусад үед Улс эсхүл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу шийдэгдээгүй маргаанд Оролцогч Талуудын Бага Хурлаас Талуудын зөвшилцөж баталсан журмын дагуу албадан биелүүлэх, арбитрын шүүгчийг хүлээн зөвшөөрч байгааг Хадгалагчид бичгээр мэдэгдэнэ.
3. Энэ зүйлийн заалтуудыг өөрөөр заагаагүй бол Талууд хоорондын аливаа протоколд хэрэглэнэ.

АРАВДУГААР ХЭСЭГ: КОНВЕНЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

28 дугаар зүйл

Энэхүү Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах

1. Аливаа Оролцогч Тал энэхүү Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгож болно. Тийм нэмэлт өөрчлөлтүүдийг Оролцогч Талуудын Бага Хурал авч хэлэлцэнэ.
2. Энэхүү Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг Оролцогч Талуудын Бага Хурал батална. Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн эх бичгийг Нарийн Бичгийн Дарга Нарын Газраас бүх Оролцогч Талуудад санал болгосон нэмэлт өөрчлөлтийг батлах хуралдаан болохоос наад зах нь 6 сарын өмнө ирүүлнэ. Нарийн Бичгийн Дарга Нарын Газар санал болгож буй нэмэлт өөрчлөлтүүдийг Конвенцид гарын үсэг зурсан Талууд мөн мэдээллийн зорилгоор Хадгалагчид ирүүлнэ.
3. Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн талаар Оролцогч Талууд зөвшилцөлд хүрэх талаар бүх хүчин чармайлт гаргана. Зөвшилцөлд хүрэх бүх хүчин чармайлт барагдаж зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд хамгийн сүүлийн арга хэмжээ болгож нэмэлт өөрчлөлтүүдийг хуралдаанд оролцож саналаа өгч буй Оролцогч Талуудын дөрөвний гурваас дээш саналаар батална. Энэ зүйлийн зорилгоор хуралдаанд оролцож саналаа өгч буй Оролцогч Талууд гэдэг нь хуралдаанд оролцож буй болон эсрэг буюу эерэг санал өгч байгаа Оролцогч Талуудыг хэлнэ. Баталсан Нэмэлт өөрчлөлтийг Нарийн Бичгийн Дарга Нарын Газраас Хадгалагчид ирүүлж тэр нь бүх Оролцогч Талуудад хүлээн зөвшөөрүүлэхээр явуулна.
4. Нэмэлт өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрсөн зөвшөөрсөн бичиг баримтуудыг Хадгалагчид хадгалуулна. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан нэмэлт өөрчлөлт нь Оролцогч Талуудын дөрөвний гурваас Дээш саналаар батлагдсан баримт бичгийг Хадгалагчид хүлээн авсан өдрөөс 19 дэх өдөр түүнийг хүлээн зөвшөөрсөн Талуудад хүчин төгөлдөр болно.
5. Аливаа бусад Оролцогч Талын хувьд дурдсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай бичиг баримтыг Эх хадгалагчид хадгалуулснаас 19 дэх өдөр энэхүү нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн хавсралт болон түүний нэмэлт өөрчлөлтийг батлах

1. Энэхүү Конвенцийн хавсралтууд болон түүний нэмэлт өөрчлөлтүүдийг 28 дугаар зүйлд заасан журмын дагуу санал болгох, батлах, хүчин төгөлдөр болгоно.
2. Энэхүү Конвенцийн хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болох ба бусад тохиолдолд өөрөөр заагаагүй бол Конвенцийн талаар лавлагаа нь нэгэн зэрэг түүний ямар нэгэн хавсралтыг лавлаж байгаа хэрэг болно. 3. Хавсралтууд нь дүрэм журам, шинжлэх ухаан, техникийн буюу захиргааны асуудалтай холбоотой жагсаалт, маягт буюу бусад тайлбарлах материалын хэлбэртэй байна.

АРВАН НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

30 дугаар зүйл

Тайлбар

Энэхүү Конвенцид ямар нэгэн тайлбар хийхгүй.

31 дүгээр зүйл

Гишүүнчлэлээс гарах

1. Оролцогч Талын хувьд энэхүү Конвенци хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жил өнгөрсний дараа хүссэн цагтаа Оролцогч Тал Конвенцоос гарах тухайгаа бичгээр Эх хадгалагчид өгөх замаар гарна.
2. Эх хадгалагч бичгээр өргөдлийг хүлээн авснаас хойш нэг жил өнгөрсний дараа гишүүнчлэлээс гарах явдал хүчин төгөлдөр болох буюу өргөдөлд дурдсан түүнээс хойших хугацаанд болно.
3. Конвенцоос гарч буй аливаа Оролцогч Талыг оролцогч болох аливаа протоколоос гарч байгаад түүнчлэн тооцно.

32 дугаар зүйл

Санал өгөх эрх

1. Энэхүү Конвенцийн Оролцогч Тал бүр энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд нэг саналын эрхтэй байна.
2. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд өөрийнхөө мэдлийн хүрээнд энэхүү Конвенцийн Оролцогч Талууд болох өөрийнх нь Гишүүн Орнуудын тоотой тэнцүү санал өгөх эрхийг эдэлнэ. Хэрэв тэдгээрийн Гишүүн Орнууд санал өгөх эрхээ эдлэхийг хүсч байгаа бол тийм байгууллага өөрийнхөө санал өгөх эрхээ эдлэхгүй байх ба энэ нь Мөн эсрэгээр байна.

33 дугаар зүйл

Протоколууд

1. Аливаа Оролцогч Тал протоколуудад санал оруулах эрхтэй. Тийм саналыг Оролцогч Талуудын Бага Хурал авч хэлэлцэнэ
2. Оролцогч Талуудын Бага Хурал энэхүү Конвенцийн протоколуудыг баталж болно. Эдгээр протоколуудыг батлахдаа зөвшилцөлд хүрэх бүх хүчин чармайлтаа гаргах ёстой. Хэрэв зөвшилцөлд хүрэх бүх хүчин чармайлтыг дуусгаж зөвшилцөлд хүрч чадаагүй бол хамгийн сүүлийн арга хэмжээ болгож протоколуудыг хуралдаанд оролцож саналаа өгч буй Оролцогч Талуудын дөрөвний гурваас дээш саналаар батална. Энэ зүйлийн зорилгоор хуралдаанд оролцож саналаа өгч буй Оролцогч Талууд гэдгийг хуралдаанд оролцож буй болон эсрэг буюу эерэг санал өгч байгаа Оролцогч Талуудыг хэлнэ.

3. Санал болгосон протоколын эх бичгийг Нарийн Бичгийн Дарга Нарын Газраас бүх Оролцогч Талуудад түүнийг хүлээн зөвшөөрөх хуралдаан болохоос наад зах нь 6 сарын өмнө ирүүлнэ.
4. Зөвхөн Конвенцийн гишүүн байгаа Оролцогч Талууд протоколд оролцогч талууд байж болно.
5. Конвенцийн аливаа протокол зөвхөн уг протоколд оролцож буй Талуудад хүчин төгөлдөр болно. Уг протоколын хүрээнд багтаж буй асуудлаар шийдвэр гаргах эрхийг зөвхөн түүний оролцогч Талууд эдэлнэ.
6. Аливаа протоколын хүчин төгөлдөр болох шаардлагууд тухайн баримт бичигт тодорхойлогдоно.

34 дүгээр зүйл

Гарын үсэг зурах

Энэхүү Конвенц Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын бүх Гишүүдэд болон Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Гишүүн бус боловч Нэгдсэн Үндэсний Байгууллагын гишүүдэд, мөн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Женев дэх Төв Байранд 2003 оны 6-р сарын 16-ны өдрөөс 2003 оны 6-р сарын 22-ны өдрийг хүртэл мөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Нью-Йорк дахь Төв Байранд 2003 оны 6-р сарын 30-ны өдрөөс 2004 оны 6-р сарын 29-ний өдрийг хүртэл гарын үсэг зурахад нээлтэй байна.

35 дугаар зүйл

Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, албан ёсоор баталгаажуулах буюу нэгдэн орох

1. Энэхүү Конвенцид Оролцогч Талууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, албан ёсоор баталгаажуулах буюу нэгдэн орох ба бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд албан ёсоор баталгаажуулах буюу нэгдэн орно. Конвенц нь түүнд гарын үсэг зурах 6 өдөр дууссанаас хойш зөвшөөрөхөд мөн нээлттэй байх болно. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, албан ёсоор баталгаажуулах буюу нэгдэн орох баримт бичгүүдийг Эх хадгалагчид хадгалуулна.
2. Энэхүү Конвенцийн гишүүн болж буй бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь түүний Гишүүн орнууд Оролцогч Тал болоогүй бол Конвенцид заасан бүх үүргийг хүлээнэ. Энэхүү байгууллагуудын нэг буюу түүнээс дээш Гишүүн Конвенцийн Оролцогч Тал болсон бол уг байгууллага болон түүний Гишүүн Орнууд Конвенцид заасан тэдгээрийн үүргийг хүлээх талаар шийдвэр гаргана. Ийм тохиолдолд байгууллага болон түүний Гишүүн Орнууд Конвенцид заасан үүргийг нэгэн зэрэг биелүүлэхийг зөвшөөрөхгүй.
3. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд Конвенцийн хүлээн зөвшөөрөх буюу нэгдэн орохтой холбоотой албан ёсны баримт бичгүүдэд Конвенцийн талаас шийдэх үйл хэргийн талаарх эрх мэдлийн хүрээг тодорхойлно. Эдгээр байгууллагууд тэдгээрийн эрх мэдлийн хүрээ их хэмжээгээр өөрчлөгдсөн талаар Эх хадгалагчид мэдэгдэж тэр нь цаашид Оролцогч Талуудад мэдээлнэ.

36 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенц гарын үсэг зурах, хүлээн зөвшөөрөх, батлах, албан ёсоор баталгаажуулах буюу зөвшөөрөх баримт бичгүүдийг Эх хадгалагчид хадгалуулснаас хойш ер дэх өдөр хүчин төгөлдөр болно.
2. Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах Улс орон бүрийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчин төгөлдөр болох нөхцөл биелэгдсэний дараа соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш ер дэх өдөр Конвенц хүчин төгөлдөр болно.
3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчин төгөлдөр болох нөхцөл биелэгдсэний дараа нэгдэн орсон буюу албан ёсоор баталгаажуулсан баримт бичгүүдийг хадгалуулсан бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага бүрийн хувьд албан ёсоор баталгаажуулсан буюу нэгдэн орсон тухай баримт бичиг бичгийг хадгалуулснаас хойш ер дэх өдөр Конвенц хүчин төгөлдөр болно.
4. Энэ зүйлийн зорилгоор, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан аливаа баримт бичиг энэхүү байгууллагын Гишүүн Улсуудаас хадгалуулсан баримт бичгүүдийн нэмэлт баримт бичиг мөн гэж тооцохгүй болно.

37 дугаар зүйл

Эх хадгалагч

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга нь энэхүү Конвенц болон 28, 29 болон 30 дугаар зүйлд заасны дагуу баталсан түүний нэмэлт өөрчлөлтүүд, протоколууд болон хавсралтуудын эх хадгалагч байна.

38 дугаар зүйл


Эх бичвэрүүд

Энэхүү Конвенцийн эх хувь болон түүний Араб, Хятад, Англи, Франц, Орос болон Испани хэл дээрх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд тэдгээрийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Даргад хадгалуулна.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН доор зохих ёсоор гарын үсэг зурах эрх олгогдсон этгээдүүд энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

ЖЕНЕВ хотноо хоёр мянга гурван оны тавдугаар сар 21-ний өдөр үйлдэв.

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийг цар тахлын даяаршлын хариу болгон боловсруулсан юм. Тамхины цар тахлыг худалдааны либералчлал, гадаадын шууд хөрөнгө оруулалт, тамхины дэлхий нийтийн маркетинг, зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа, тамхины хууль бус худалдаа зэрэг хил дамнасан нийлмэл хүчин зүйлс өдөөж байдаг. ДЭМБ-ын ТХСК нь бүх хүний эрүүл мэндийн байж болох хамгийн дээд түвшинд хүрэх эрхийг баталгаажуулсан, нотолгоонд тулгуурласан олон улсын гэрээ юм.



Конвенцийн Нарийн бичгийн даргын газар
ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
Avenue Appia 20, 1211 Geneva 27, Switzerland
Утас: +41 22 791 50 43
Факс: +41 22 791 58 30
И-мэйл: fctcsecretariat@who.int
Вэб хуудас: www.fctc.who.int
ISBN 978-92-4-151214-5